



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/124/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ
Утас: 261740 Цахим хаяг: bolorderned@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ашид баланс аудит ХХК
Захирал: Л.Майцэцэг
Утас: 99081568 Цахим хаяг: ashidbalance@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/422
танай _____-ны № _____-т

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН
ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВИЙН
ЗАХИРАЛ А.БУЯННЭМЭХ
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар залруулагдаагүй 85,677.7 мянган төгрөгийн зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, Захиргааны Ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2, Нийцсэн бөгөөд зохистой байх, Тохиолдсон байх, Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	28,923,528.00	31,201,047.00
33	Авлага	8,496,200.00	8,496,200.00
335	Бусад авлага	8,496,200.00	8,496,200.00
3351	Байгууллагаас авах авлага	8,496,200.00	8,496,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	20,427,328.00	22,704,847.00
351	Түүхий эд материал	19,364,596.00	21,724,215.00
35110	Тусгай зориулалттай материал	19,364,596.00	21,724,215.00
354	Хангамжийн материал	1,062,732.00	980,632.00
35410	Бичиг хэргийн материал	258,800.00	4,800.00
35410	Аж ахуйн материал	-	171,900.00
35420	Бусад хангамжийн материал	803,932.00	803,932.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,735,188,407.20	1,724,485,329.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,735,188,407.20	1,724,485,329.96
392	Биет хөрөнгө	15,412,073.92	10,200,830.08
39203	Авто тээврийн хэрэгсэл	57,338,000.00	57,338,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(57,338,000.00)	(57,338,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	43,222,179.00	43,531,490.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,900,481.24)	(37,748,465.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,187,687.18	26,974,857.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,097,311.02)	(22,557,051.78)
393	Биет бус хөрөнгө	1,719,776,333.28	1,714,284,499.88
39301	Програм хангамж	85,551,000.00	85,551,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(51,774,666.72)	(57,266,500.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,686,000,000.00	1,686,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ҮР ДҮН	1,764,111,935.20	1,755,686,376.96
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,764,111,935.20	1,755,686,376.96
51	Засгийн газрын хувь оролцоо	1,764,111,935.20	1,755,686,376.96
	Эздийн өмчийн бусад хэсэг	1,615,360,000.00	1,615,360,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	148,751,935.20	140,326,376.96
51210	Өмнөх үеийн үр дүн	91,319,455.59	148,751,935.20
51220	Тайлант үеийн үр дүн	57,432,479.61	(8,425,558.24)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,764,111,935.20	1,755,686,376.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ҮР ДҮН	779,024,600.00	688,089,119.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,640,000.00	1,849,719.00
120	Нийтлэг татварын бус орлого	70,640,000.00	1,849,719.00
120002	Төсөвт байгууллагын өөрийн орлого	70,640,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	70,640,000.00	-
120017	Үнэ төлбөргүй /Үндсэн хөрөнгө/ авсан	-	973,100.00
120018	Үнэ төлбөргүй /Бараа материал/ авсан	-	876,619.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	708,384,600.00	686,239,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	708,384,600.00	686,239,400.00
1310001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	708,384,600.00	686,239,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	721,592,120.39	695,535,244.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	721,592,120.39	695,535,244.16
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	721,592,111.02	693,533,698.04
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	403,785,759.83	403,736,991.46
210101	Цалингийн зардал	275,389,560.00	283,785,530.44
210102+	Нэмэгдэл цалин	110,427,699.83	77,760,152.66
210103+	Унаа, хоолны хөнгөлөлт	17,968,500.00	42,191,308.36
2102	Ажил олгогчоос НДШ-ийн зардал	51,879,925.88	53,782,557.71
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	35,100,435.52	38,363,700.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,029,141.81	3,991,730.24
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,223,313.45	2,960,567.37
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	782,803.31	1,064,641.74
210105	Эрүүл мэндийн даатгалын хураамж	8,744,231.78	7,401,918.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,822,600.00	121,822,600.00
210304	Байрны түрээсийн зардал	121,822,600.00	121,822,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	50,760,480.62	29,994,059.66
210401	Бичиг хэргийн зардал	12,024,270.00	9,721,150.00
210402	Тээвэр, шатахууны зардал	9,367,400.00	3,497,100.00
210403	Шуудан, холбооны зардал	8,684,540.12	4,230,704.66
210404	Ном хэвлэлийн зардал	2,002,700.00	3,549,855.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,001,750.00	8,995,250.00
210408	Бараа материал акталсны зардал	13,679,820.50	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,160,800.00	12,101,800.00
210601	Багаж хэрэгсэл	7,844,800.00	11,947,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	316,000.00	154,200.00
2107	Томилолт, зочдын зардал	200,000.00	-

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолтын зардал	200,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,426,050.00	50,356,205.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24,545,400.00	13,923,066.80
210802	Аудит баталгаажуулах зардал	1,485,000.00	1,226,930.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	540,000.00	470,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	135,100.00	113,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээний хөлс	30,944,700.00	30,178,508.25
210807	Газрын төлбөр	-	93,400.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	3,775,850.00	4,329,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,556,494.69	21,739,484.16
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	11,728,064.80	10,069,640.00
210903	Элэгдлийн зардал	11,828,429.89	11,669,844.16
2132	Урсгал шилжүүлэг	9.37	2,001,546.12
213201	Бусад урсгал шилжүүлэг	-	868,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9.37	1,133,546.12
КТ(213303)	Төвлөрүүлэх шилжүүлэг	9.37	1,133,546.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	57,432,479.61	(7,446,125.16)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	(979,433.08)
КТ(225005)	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	(979,433.08)
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	(979,433.08)
6	НИЙТ ҮР ДҮН	57,432,479.61	(8,425,558.24)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,615,360,000.00	-	91,319,455.59	1,706,679,455.59
Дахин илэрхийлэх үлдэгдэл	1,615,360,000.00	-	91,319,455.59	1,706,679,455.59
Тайлант үеийн үр дүн	-	-	57,432,479.61	57,432,479.61
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,615,360,000.00	-	148,751,935.20	1,764,111,935.20
Дахин илэрхийлэх үлдэгдэл	1,615,360,000.00	-	148,751,935.20	1,764,111,935.20
Тайлант үеийн үр дүн	-	-	(8,425,558.24)	(8,425,558.24)
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,615,360,000.00	-	140,326,376.96	1,755,686,376.96

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	708,384,600.00	686,239,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	708,384,600.00	686,239,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	708,384,600.00	686,239,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	708,384,600.00	686,239,400.00
2	УРСГАЛ ЗАРДАЛ	708,384,600.00	686,239,400.00
21	Бараа ажил, үйлчилгээний зардал	708,384,590.63	684,237,853.88
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	403,785,759.83	403,736,991.46
210101	Үндсэн цалин	275,389,560.00	283,785,530.44
210102	Нэмэгдэл	110,427,699.83	77,760,152.66
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,968,500.00	42,191,308.36
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл	51,879,925.88	53,782,557.71
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	34,548,833.57	38,363,700.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,052,192.85	3,991,730.24
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,230,600.00	2,960,567.37
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,971,699.46	1,064,641.74
210105	Эрүүл мэндийн даатгалын хураамж	8,076,600.00	7,401,918.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,822,600.00	121,822,600.00
210304	Байрны түрээс	121,822,600.00	121,822,600.00
220103	Хангамж, бараа материалын зардал	34,271,990.12	26,522,259.66
210401	Бичиг хэргийн зардал	8,485,700.00	8,931,500.00
210402	Тээвэр, шатахуун	8,949,100.00	3,497,100.00
210403	Шуудан холбооны зардал	9,102,840.12	4,230,704.66
210404	Ном, хэвлэлийн зардал	4,262,100.00	3,549,855.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардал	3,472,250.00	6,313,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,479,700.00	13,457,900.00
210601	Багаж техник хэрэгсэл	14,629,700.00	11,947,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,850,000.00	1,510,300.00
2107	Томилолт, зочны зардал	200,000.00	-
210702	Дотоод томилолтын зардал	200,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,216,550.00	54,845,905.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,545,400.00	17,969,966.80
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,485,000.00	1,226,930.00
210803	Даатгалын үйлчилгээ	540,000.00	470,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	135,100.00	113,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,156,400.00	30,475,508.25
210807	Газрын төлбөр	-	93,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,354,650.00	4,474,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,728,064.80	10,069,640.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,728,064.80	10,069,640.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9.37	2,001,546.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	868,000.00

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	868,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9.37	1,133,546.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9.37	1,133,546.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
10	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
11	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
12	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	686,239,400.00	685,105,853.88	1,133,546.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	686,239,400.00	685,105,853.88	1,133,546.12
210	Бараа ажил, үйлчилгээний зардал	685,365,900.00	684,237,853.88	1,128,046.12
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	403,828,600.00	403,736,991.46	91,808.54
210101	Үндсэн цалин	275,432,600.00	283,785,530.44	(8,352,930.44)
210102	Нэмэгдэл	110,427,700.00	77,760,152.66	32,667,547.34
210103	Унаа болон бусад нөхөн олговор	17,968,500.00	42,191,308.36	(24,222,808.36)
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл	54,516,900.00	53,782,557.71	734,342.29
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	38,363,700.00	38,363,700.00	-
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,038,300.00	3,991,730.24	46,569.76
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,230,600.00	2,960,567.37	270,032.63
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	807,700.00	1,064,641.74	(256,941.74)
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	8,076,600.00	7,401,918.36	674,671.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,822,600.00	121,822,600.00	-
210303	Байрны түрээс	121,822,600.00	121,822,600.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	26,523,800.00	26,522,259.66	1,540.34
210401	Бичиг хэргийн зардал	7,000,700.00	8,931,500.00	(1,930,800.00)
210402	Тээвэр, шатахуун	6,363,600.00	3,497,100.00	2,866,500.00
210403	Шуудан холбооны зардал	7,560,400.00	4,230,704.66	3,329,695.34
210404	Ном, хэвлэлийн зардал	3,551,800.00	3,549,855.00	1,945.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлсийн зардал	2,047,300.00	6,313,100.00	(4,265,800.00)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,458,000.00	13,457,900.00	100.00
210601	Багаж техник хэрэгсэл	11,947,600.00	11,947,600.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,510,400.00	1,510,300.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	158,200.00	-	158,200.00
210702	Дотоод томилолтын зардал	158,200.00	-	158,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,981,800.00	54,845,905.05	135,894.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	17,970,400.00	17,969,966.80	433.20

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	үйлчилгээний төлбөр хураамж			
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,237,500.00	1,226,930.00	10,570.00
210803	Даатгалын үйлчилгээ	470,200.00	470,200.00	-
210804	Тээврийн хэрэгслэлийн татвар	214,500.00	113,100.00	101,400.00
210805	Тээврийн хэрэгслэлийн оношлогоо	37,500.00	22,000.00	15,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	30,483,500.00	30,475,508.25	7,991.78
210807	Газрын төлбөр	93,400.00	93,400.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,474,800.00	4,474,800.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,075,800.00	10,069,640.00	6,160.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,075,800.00	10,069,640.00	6,160.00
210902	Нийт зардал ба зээлийн дүн	873,500.00	868,000.00	5,500.00
213	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	873,500.00	868,000.00	5,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	873,500.00	868,000.00	5,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	873,500.00	868,000.00	5,500.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	686,239,400.00	685,105,853.88	1,133,546.12
35	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	686,239,400.00	685,105,853.88	1,133,546.12
3	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО			
62	Ажиллагсдын тоо	25	33	8
62001	Удирдах ажилтан	1	1	-
62002	Гүйцэтгэх ажилтан	24	24	-
62003	Гэрээт ажилтан	-	8	8

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулах, төсвийн зардлын ангиллыг зөв бүртгэж тайлагнаж байх, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд онцгой нөхцөл (бүх нийтийг хамарсан) үүссэн үед ажил олгогч нь ажилтны ажлын цаг, амралтын цаг, цалин хөлс, нэмэгдлийг хэрхэн тооцох, олгох талаар нэмж оруулах, төсвийн тэвчиж болох зардлын хэмнэлтийг гаргаж ажиллах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 15-аас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ашид баланс аудит ХХК-ийн захирал Л.Майцэцэг, ахлах аудитор Д.Гандолгор, аудитор Д.Алтанцэцэг, аудиторын туслах Д.Сэрчинмаа нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Л.Оюунчимэг хэрэгжүүлсэн.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн эрхэм зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй, шуурхай, найдвартай, үр ашигтай удирдлага, зохицуулалтын нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх явдал юм.

Тус төв нь 2021 оныг “Цахим шилжилтийн жил” болгон зарласантай холбогдуулан төвийн үйл ажиллагаа, төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичиг, албан хэрэг хөтлөлтийг тоон гарын үсэгт шилжүүлэн цахимаар мэдээлэл солилцох жагсаалт, цахим шилжилт хийх чиглэлээр ажлын төлөвлөгөө, заавар батламж хэрэгжүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус төвийн дотоод хяналтын ажилтан нь сар бүр байгууллагын үйл ажиллагаа, ажлын цаг ашиглалт, дээд байгууллагаас ирсэн тушаал, албан даалгаврын биелэлтийг хянаж үр дүнг тухай бүр тайлагнадаг боловч санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг хийдэггүй байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2021 оны 12 дугаар сард тус төвийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж нийт 7 үзүүлэлтээр 129 арга хэмжээг дүгнэж нэгдсэн дүнгээр 90.0 хувьтай гэж дүгнэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 721,592.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7,215.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,425.6 мянган төгрөгөөр буюу 0.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн дансдууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	20,427.3	22,704.8	2,277.5
Үндсэн хөрөнгө	1,735,188.4	1,724,485.3	(10,703.1)
Нийт хөрөнгө	1,764,111.9	1,755,686.4	(8,425.6)
Хуримтлагдсан үр дүн	147,751.9	140,326.4	(8,425.6)

Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,764,111.9	1,755,686.4	(8,425.6)
---	--------------------	--------------------	------------------

Бараа материалын дансны үлдэгдэл 22,704.8 мянган төгрөг болж, 2,277.5 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн болон хөдөлмөр хамгааллын материалын худалдан авалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,724,485.3 мянган төгрөг болж, 10,703.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн санхүүжилтийн орлого өмнөх оноос 22,145.2 мянган төгрөг буюу 3.1 хувиар буурсан байна.

Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 97.4 хувиар буурсан нь өмнөх онд ТӨБЗГ-ын 2020 оны 514 дүгээр тогтоолоор Налайх АЗЗА ТӨХК-аас 70,640.0 мянган төгрөгийн үнэ бүхий 4000 м.кв газар эзэмших эрх үнэ төлбөргүй шилжиж ирснээс шалтгаалсан байна.

Нийт үйл ажиллагааны зардал 26,056.9 мянган төгрөг буюу 3.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бусад бараа ажил үйлчилгээний зардал, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлууд байгаа нь төсвийн санхүүжилтийн орлого буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,142,851.9 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 434,746.5 мянган төгрөг буюу 38.1 хувиар бууруулж, 708,105.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Тухайлбал цалин, нийгмийн даатгал 119,437.9 мянга, томилот 117,108.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 72,121.3 мянга, байр ашиглалт 43,249.4 мянган төгрөг зэрэг зардлуудыг тус тус бууруулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 708,105.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 21,866.0 мянган төгрөгийг дахин танаж, гүйцэтгэлээр 686,239.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 686,239.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 685,105.9 мянган төгрөгийг зарцуулж, 1,133.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 685,105.9 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 135.9 мянга, бараа үйлчилгээний урсгал зардлыг 6.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71103	Зам, тээврийн салбар	686,239.4	685,105.9	(1,133.5)	99.8
1.1	80101	Үйл ажиллагааны урсгал зардал	685,365.7	684,237.9	(1,127.8)	99.8
1.2	80802	Бусад урсгал шилжүүлэг	873.7	868.0	(5.7)	99.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас тус төвийн 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд нийт 42 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн 26, 90.0 хувийн 2, 70.0 хувийн 7, 50.0 хувийн 4, 30.0 хувийн 3 арга хэмжээ нийт 84.8 хувийн биелэлттэй гэж үнэлсэн байна.

Биелэлт хангалтгүй буюу 30.0 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн дараах 3 арга хэмжээ нь Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаагүй мөн ковид-19 цар тахлын нөлөөллөөс үүдэн барилгын материалын татан авалт, тээвэр, үнийн өсөлтөөс шалтгаалан ажилчдын орон сууц хугацаандаа баригдаж дуусаагүй зэрэг шалтгаанууд нөлөөлсөн байна. Үүнд:

- Төмөр замын тээвэрлэлттэй холбоотой ажил, үйлчилгээ бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ, үнэлгээ, баталгаажуулалтыг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх журмын төслийг боловсруулах;
- Галт тэрэгний хөдөлгөөнийг удирдан зохицуулах радио зурвасыг хуваарилах, хяналт тавих, технологийн судалгаа хийх;
- Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв болон яам, харьяа газруудын албан хаагчдын орон сууцны барилга ашиглалтад оруулах;

3.8 Аудитын гол асуудал

Төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлагдсан төсвийн талаар албан бичиг, шийдвэр хавсарган ирүүлдэггүй, төсвийн төсөлтэй холбоотой тайлбар тодруулгыг авалгүй төсвийг үндэслэлгүй бууруулж төрийн сангийн системд оруулдаг дутагдал нийтлэг байна.

Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл, бүртгэлийн суурь, бодлогын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв нь 2021 онд нийт 810,865.9 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 690,865.9 мянган төгрөгийн 19 мэдээллийг байршуулаагүй, 10,000.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв нь хуулиар заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй оффисийн түрээсийн гэрээг Газар шилтгээн ХХК-тай байгуулахдаа нээлттэй тендер шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй, “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалтыг зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална”, 8 дугаар зүйлийн 8.1-д “Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно”, 8.2-д “энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Босго үнээс давсан төсөвт өртөгтэй ажил, үйлчилгээг худалдан авахад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлээгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг худалдан авах ажиллагаандаа хэрэгжүүлж, зохион байгуулж ажиллагаагүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 127,408.1 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илрүүлснээс 126,333.8 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлагын санал хүргүүлж, 1,074.3 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад амралтын илүү олгосон мөнгийг нэр бүхий ажилчдаас суутган тооцоогүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 600.0 мянган төгрөгийн зөрчилд тогтоосон 1 төлбөрийн акт биелсэн, шилэн дансны хуулийн хэрэгжилтийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага биелээгүй байна. Аудитаар өгсөн 4,870.6 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	600.0	1	600.0	-	-	-
Албан шаардлага	1	-	1	-	-	-	-
Зөвлөмж	3	4,870.6	3	4,870.6	-	-	-
Нийт дүн	5	5,470.6	5	5,470.6	-	-	100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн биет бус хөрөнгийн дансанд 1,615,360.0 мянган төгрөгийн үнэ бүхий 1261м.кв болон 70,640.0 мянган төгрөгийн үнэ бүхий 4000 м.кв газар бүртгэлтэй байна.

Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 000002081 дугаартай Баянгол дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 1261м/кв газрыг орон сууц, конторын зориулалтаар 15 жилийн хугацаатай газар эзэмших гэрчилгээг олгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 39 дүгээр тушаалаар “Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажлын хэсэг байгуулагдсан.

Уг хөтөлбөрийн хүрээнд “Ди Ди Эм Ти” ХХК-тай 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 21033101 дугаартай “Зам, тээврийн хөгжлийн яам болон галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн ажилтнуудыг орон сууцжуулах барилгын ажлын гэрээ”-г байгуулж гэрээнд заасны дагуу орон сууцны барилгыг 2021 оны 12 дугаар сарын 31-ний дотор бүрэн дуусгаж барилгыг ашиглалтад оруулж, комисст хүлээлгэн өгөх байсан боловч гэрээнд заасан хугацаанд баригдаж дуусаагүй, зогсонги байдалтай байна.

Орон сууцны барилгын ажлын гүйцэтгэгч байгууллагыг сонгохдоо нээлттэй тендер шалгаруулалт явуулаагүй, шууд гэрээ байгуулан орон сууц барих ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Дээрх газар нь орон сууц, конторын зориулалтаар эзэмших эрхийн гэрчилгээтэй боловч холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүй зориулалтыг өөрчилж, 1-10 давхар 80 айлын орон сууцны барилга барьж эхэлсэн байна.

Иймд дараагийн аудитаар газар эзэмших зориулалт болон түүнтэй холбоотой асуудал, орон сууцны барилга барих гэрээний хэрэгжилтийг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 185,700.5 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 100,022.8 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 1,074.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 14,155.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 70,447.8 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 85,677.7 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 7,215.9 мянган төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Өмчийн өөрчлөлтийн тайлангийн хуримтлагдсан үр дүнгийн эхний үлдэгдлийг 100,022.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;

4.2 Төлбөрийн акт

Нэр бүхий 16 ажилчдын ээлжийн амралтын тооцоог 1,074.3 мянган төгрөгөөр илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлтэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчим” гэж заасантай нийцэхгүй, “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4.3 Албан шаардлага

1. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв, ОХУ-ын Эрхүү хотын Зам харилцааны их сургууль хооронд хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд тус төвийн нэр бүхий 4 ажилтны бакалаврын сургалтын төлбөр 6,333.9 мянган төгрөгийг удирдлагын тушаал, шийдвэргүйгээр ажилчдын хувийн дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлтэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 43 дугаар тогтоолын 1.5-д “салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал зөвлөгөөн, газар дээрх хяналт шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж сургалт, семинар, хурал зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлын хэмнэх” гэж заасантай тус тус нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

2. Тайлант онд анхан болон хяналтын шатны шүүхийн тогтоолоор нийт 7,821.7 мянган төгрөгийн ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын нөхөн олговрыг нэр бүхий хоёр ажилтанд олгосон боловч байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т “Иргэн хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага, Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухай захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж заасантай нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна..

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэх

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Тайлант онд нэр бүхий 11 байгууллагаас худалдан авсан 37,974.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээ нь төлбөрийн и баримтаар баталгаажуагүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “... Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар эсхүл анхан шатны баримтаар баталгаажуагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг мөрдөж ажиллах;

2.1 Илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайланд 4,908.6 мянган төгрөгийн газрын төлбөрийг хичээл үйлдвэрлэл, ном хэвлэл, аудит баталгаажуулах зэрэг зардалд хуваарилан бүртгэж зардлын эдийн засгийн ангиллыг бүлэг хооронд шилжүүлэн тайлагнасан байна.

2.2 Өгсөн зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж төсвийн зардлын ангиллыг зөв бүртгэж тайлагнаж байх

2. Засгийн газрын тогтоол, заавар, журамтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтнуудыг алсын зайнаас цахимаар ажиллуулах түр журмын дагуу ажилласан ажиллагсдад ирэх очих хоол, унааны зардалд 27,565.2 мянган төгрөг олгосон байна.

Өгсөн зөвлөмж:

Хөдөлмөрийн тухай шинэчилсэн хуулийг үндэслэн байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт онцгой нөхцөл (бүх нийтийг хамарсан) үүссэн үед ажил олгогч нь ажилтны ажлын цаг, амралтын цаг, цалин хөлс, нэмэгдлийг хэрхэн тооцож, олгох талаар нэмэлт өөрчлөлт оруулах, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”, 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 183 дугаар тогтоол “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”, 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 211 дүгээр тогтоол “Коронавирус халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл, өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон төсвийн тэвчиж болох зардлын хэмнэлтийг гаргаж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв	АХГ-2022/124 /НА-СТА-ТШЗ	Өмчийн өөрчлөлтийн тайлангийн хуримтлагдсан үр дүнгийн эхний үлдэгдлийг 100,022.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн.	Холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх	1	100,022.8	1	100,022.8	-	-	-	-	-	-
2	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв	АХГ-2022/124 /НА-СТА-ТШЗ	Нэр бүхий 16 ажилчдын ээлжийн амралтын тооцооллыг буруу хийж, амралтын мөнгө илүү олгосон.	Төсвийн тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажиллах	1	1,074.3	-	-	1	1,074.3	-	-	-	-
3	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв	АХГ-2022/124 /НА-СТА-ТШЗ	Тайлант онд анхан болон хяналтын шатны шүүхийн тогтоолоор ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын нөхөн олговрыг нэр бүхий 2 ажилтанд олгосон боловч байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлээгүй байна.	Захиргааны ерөнхий хуулийн дагуу нөхөн олговрыг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх	1	7,821.7	-	-	-	-	1	7,821.7	-	-
4	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалт	АХГ-2022/124 /НА-СТА-ТШЗ	Нэр бүхий 11 байгууллагаас худалдан авсан 37,974.0 мянган төгрөгийн бараа, ажил	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтын иж	1	37,974.0	-	-	-	-	-	-	1	37,974.0

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	ын нэгдсэн төв		үйлчилгээ нь төлбөрийн и баримтаар баталгаажуулахгүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	бүрдлийг хангаж ажиллах											
5	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв	АХГ-2022/124 /НА-СТА-ТШЗ	Төсвийн гүйцэтгэлийн тайланд газрын төлбөрийг хичээл үйлдвэрлэл, ном хэвлэл, аудит баталгаажуулах зэрэг зардалд хуваарилан бүртгэж, зардлын эдийн засгийн ангиллыг бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан байна.	Эдийн засгийн ангилалыг журмын дагуу зөв ангилж бүртгэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах	1	4,908.6	-	-	-	-	-	-	1	4,908.6	
6	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв	АХГ-2022/124 /НА-СТА-ТШЗ	Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, төвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтнуудыг зайнаас цахимаар ажиллуулах түр журмын дагуу ажилласан ажиллагсдад ирэх очих хоол, унааны мөнгө олгосон.	Хөдөлмөрийн тухай шинэчлэн баталсан хуулийн дагуу байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулж, дагаж мөрдөх	1	27,565.2	-	-	-	-	-	-	1	27,565.2	
7	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв	АХГ-2022/124 /НА-СТА-ТШЗ	ГТХЗНТ, ОХУ-ын Эрхүү хотын зам харилцааны их сургууль хооронд хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд тус төвийн нэр бүхий 4 ажилтны бакалаврын сургалтын төлбөрийг удирдлагын тушаал шийдвэргүйгээр ажилчдын хувийн	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу зардлыг хэмнэж ажиллах	1	6,333.9	-	-	-	-	1	6,333.9	-	-	

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

			дансанд шилжүүлсэн байна.											
ДҮН					7	185,700.5	1	100,022.8	1	1,074.3	2	14,155.6	3	70,447.8
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв	АХГ-2022/124 /НА-СТА-ТШЗ	Төв нь хуулиар заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй ажил үйлчилгээ худалдан авахдаа нээлттэй тендер шалгаруулалт явуулаагүй, Газар шилтгээн ХХК-тай оффисийн түрээсийн шууд гэрээ байгуулсан байна.	ТБОНӨХБАУХА тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.	1	120,000.0	-	-	-	-	1	120,000.0	-	-
2	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв	АХГ-2022/124 /НА-СТА-ТШЗ	Тайлант хугацаанд байршуулбал зохих нийт 151 мэдээллээс, хугацаа болоогүй 8, хугацаа хоцроож байршуулсан 10,000.0 мянган төгрөгийн 2, шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй 690,865.9 мянган төгрөгийн 19 мэдээлэл байна.	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	1	-	-	-	-	-	1	-	-	-
ДҮН					2	120,000.0	-	-	-	-	2	120,000.0	-	-
НИЙТ ДҮН					9	305,700.5	1	100,022.8	1	1,074.3	4	134,155.6	3	70,447.8



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 36/ А0150458

Улаанбаатар хот

АХГ - 2022/124/НА - СТА - ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд нэр бүхий 16 ажилтанд ээлжийн амралтын олговор 1,074,278.34 төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлтэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 "Ээлжийн амралтын олговрыг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлсний хэмжээгээр тогтооно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**


1. Нэр бүхий 16 ажилтанд илүү олгосон ээлжийн амралтын олговор 1,074,278.34 /нэг сая далан дөрвөн мянга хоёр зуун далан найм/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн захирал А.Буяннэмэх, нягтлан бодогч С.Золзаяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР: С.НАЦАГДОРЖ

АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР: Д.ГАНДОЛГОР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 201/АО/50458
АХГ-2022/124/НА-СТА-ТЦЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд анхан болон хяналтын шатны шүүхийн тогтоолоор нийт 7,821,706.01 төгрөгийн ажилгүй байсан хугацааны нийгмийн даатгалын нөхөн олговрыг нэр бүхий хоёр ажилтанд олгосон боловч байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлээгүй байна

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага, Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", 103.2 "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухай захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Нэр бүхий хоёр ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олголт олгосон нийт 7,821,706.01 /Долоон сая найман зуун хорин нэгэн мянга долоон зуун зургаа/ төгрөгийг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга М.Энх-Одод даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Д.ГАНДОЛГОР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 11-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9006109 1\0.10.10.20\Bichig\Khereg\Alban Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-212.Docx
9019120390

0010800680



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

№ 022/АД/50458

Улаанбаатар хот

АХГ-0022/104/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд

Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв, ОХУ-ын Эрхүү хотын Зам харилцааны их сургууль хооронд байгуулсан хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд тус төвийн нэр бүхий дөрвөн ажилтны бакалаврын сургалтын төлбөр 6,333,856.40 төгрөгийг удирдлагын тушаал, шийдвэргүйгээр ажилчдын хувийн дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлтэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 43 дугаар тогтоолын 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал зөвлөгөөн, газар дээрх хяналт шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж сургалт, семинар, хурал зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлын хэмнэх" гэсэн заалтуудад нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд тус төвийн нэр бүхий дөрвөн ажилтны бакалаврын сургалтын төлбөр 6,333,856.40 /зургаан сая гурван зуун гучин гурван мянга найман зуун тавин зургаа/ төгрөгийг удирдлагын тушаал, шийдвэргүйгээр ажилчдын хувийн дансанд шилжүүлсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн захирал А.Буяннэмэх, нягтлан бодогч С.Золзаяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Д.ГАНДОЛГОР

9006109

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тайруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264239.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-213.Docx

0010800683



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 223/АО15 0458
АХГ-2022/104/АА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд

Тайлант онд Засгийн газраас босго үнээс дээш төсөвт өртөгтэй оффисын түрээсийн гэрээг Газар шилтгээн ХХК-тай байгуулахдаа нээлттэй тендер зарлаж, сонгон шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулаагүй, "Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалтыг зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1. "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 8 дугаар зүйлийн 8.1 "Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно", 8.2 "Энэ хуулийн 8.1.1 "заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн захирал А.Буяннэмэх, нягтлан бодогч С.Болзаяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Д.ГАНДОЛГОР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-214.Docx

0010800687



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 288/А0150458

Улаанбаатар хот

АХГ-2022/124/НА-СТА-ТМЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих нийт 151 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож, 19 мэдээллийг байршуулаагүй алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй, буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн захирал А.Буяннэмэхэд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ

Д.ГАНДОЛГОР

